



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 191

Улаанбаатар хот

“Замын-Үүдийн дулааны станц”
төрийн өмчит үйлдвэрийн газрын 2024 оны эдийн
засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон
Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний
биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 3.1, 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Замын-Үүдийн дулааны станц” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Захирал О.Төмөрхуягтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2. “Замын-Үүдийн дулааны станц” төрийн өмчит үйлдвэрийн газрын Захирал О.Төмөрхуягтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ шинэчлэн байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ